



Ерөнхийлөгч
Диетер Ф.Угдорф
Тэргүүн Зөвлөлийн
Хоёрдугаар зөвлөх

Сайн сайхан зүйлсийг эрэлхийлэх нь

Шинэ байшин худалдан авахаар хайж байсан Хожмын Үеийн Гэгээнтэн залуу хос ирээдүйн хөршүүдтэйгээ тэр орчмын сургуулиудийн талаар ярилцжээ.

Хүүхдүүд нь тэр хавийн сургуульд явдаг нэгэн эмэгтэй “Энэ бол хамгийн сайн сургууль”. “Захирал нь үнэхээр гайхалтай сайн хүн, багш нар нь туршлагатай, сайхан сэтгэлтэй, найрсаг манай хүүхдүүд энэ гайхалтай сургуульд суралцаж байгаад би үнэхээр баяртай байгаа та нарт энд байх их таалагдах болно” гэж хэлэв.

Өөр нэгэн эмэгтэй хүүхдүүдийнхээ сургуулийг “Үнэхээр аймшигтай газар, захирал нь биеэ тоосон, багш нар нь туршлагагүй, бүдүүлэг, найрсаг биш. Хэрвээ надад хангалттай мөнгө байсан бол энэ газраас бушуухан нүүх байсан” гэв.

Сонирхолтой нь энэ 2 эмэгтэй хоёулаа нэг сургуулийн захирал болон багш нарын талаар ярьж байсан юм.

Та бүхэн хүмүүсийг аливаа зүйлсийг өөр өөрийнхөө хүссэнээр л хардаг болохыг хэзээ нэгэн цагт анзаарч байсан уу? Хэрвээ та сайн анзаарвал хүмүүст болон аливаа зүйлст сайн муу хоёр тал байдгийг харж чадна. Хүмүүс Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн сүмийг үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн мөн ийнхүү хандаж ирсэн. Сайныг харахыг хүсэгчид сүмийн гишүүдийг сайхан сэтгэлтэй,

энэрэнгүй Их Эзэнд хайртай, Түүнд үйлчлэх хүсэлтэй бөгөөд эргэн тойрныхоо хүмүүсийн амьдралыг адисалсан хүмүүс гэж хардаг. Гэвч өө хайгчид муу зүйлсийг олж харах нь зайлшгүй.

Харамсалтай нь иймэрхүү зүйлс сүмд ч мөн хааяа нэг тохиолддог билээ. Шүүмжлэх шалтаг хайсан хүнд хангалттай олон шалтаг, сэдэв байдаг. Тэд атаархлаа барьж дийлдэггүй юм шиг санагддаг. Хов живээр хөөцөлдөж, хүмүүсээс өө хайдаг нэгэн нь муу санаа өвөрлөж, боломж л гарвал хүмүүсийг шүүмжилж, доромжлон гутаахыг эрэлхийлдэг. Иймэрхүү зан байдал Их Эзэнд таалагддаггүй. Иаков 3:16-д “Учир нь хаана атаархал ба хувиа хичээсэн зорилго оршиж байна, тэнд замбараагүй байдал болоод аливаа бузар юм нь байдаг” хэмээн гардаг билээ.

Ерөнхийлөгч Жорж К.Каннон (1827–1901)
Ерөнхийлөгч Бригам Янгтай (1801–77)
Арванхоёрын Чуулгад гишүүнээр болон Тэргүүн Зөвлөлд түүний туслахаар олон жил ажиллажээ.
Ерөнхийлөгч Янгийг нас нөгчсөний дараа
Ерөнхийлөгч Каннон тэмдэглэлийн дэвтэртээ
“Би хэзээ ч Ерөнхийлөгч Бригам Янгийн удирдах арга барил, шийдвэрт алдаа хайж, шүүмжилж байгаагүй. Тэр бүү хэл зүрх сэтгэлээрээ, үг хэл, үйлдэлээрээ ч шүүмжилж байсангүй ээ” гэж тэмдэглэн үлдээсэн байдаг. Энэ нь надад одоо сайхан байдаг. Хэрвээ би Бригам ахаас

өө хайж, түүнийг шүүмжилж эхэлвэл хэзээ, хэрхэн зогсохоо хянаж чадах чадвартай байсан болов уу? Би ингэхийг өөртөө зөвшөөрөөгүй юм. Бусдыг шүүмжилж, бусдын өөг хайснаар энэ нь эцэстээ сүмээс урвахад хүргэсэн нэг бус тохиолдлыг би мэддэг байсан. Миний хийж зүрхлээгүй олон зүйлсийг надаас илүү хүчтэй, ухаантай, туршлагатай хүмүүс муу үр дагаварт нь авталгүйгээр үйлддэг байх.¹

Ерөнхийлөгч Канноны энэхүү хүчирхэг зөвлөгөөг бид сүмийн гишүүдийн хувьд анхааралтайгаар тунгаан бодох хэрэгтэй. Бурханы үг Христийн дагалдагчдыг “ариун хийгээд амар тайван, эелдэг, бат суурьтай, өршөөл, энэрэл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй” хүмүүс болгодог. Эдгээр амар амгаланг тогтоогчдоод “зөв шударгын үр жимс нь амар амгаланд таригддаг юм” хэмээсэн байдаг (Иаков 3:17, 18).

Бид өөрсдөө бусдаас хүсэн хүлээдэг шигээ амар амгаланг тогтоож, бусдыг ойлгож, шударга, энэрэнгүй байх эсвэл бусдаас өө дутагдал хайж, шүүмжлэх эсэх нь бидний сонголт юм. Ямар зүйл хайна тэр зүйлээ олох нь гарцаагүй. Энэ бол бидний л сонголт.

ЭШЛЭЛ

1. Ерөнхийлөгч Жорж К.Канноны тэмдэглэлийн дэвтэр 1878-1-17. шинэчилсэн хувилбар.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Та заахаар зэхэж буй хичээлийнхээ зарчмыг сайн ойлгохгүй байгаа мэт санагдах үедээ *Багшлахаас илүү дуудлага* гэж үгүй номыг (1999-19) санаарай. Та залбиралтайгаар суралцаж, бэлдээд бусдад заавал таны өөрийн тань гэрчлэл хүчирхэгжиж, бат бэх болно.

Энэ сарын турш та амьдралаас болон бусдаас сайн сайхныг эрэлхийлвэл энэ хичээлийг заахад илүү сайн бэлтгэгдэж, үүний үнэнийг гэрчилж чадна.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Азгүй тохиолдлоос сайн зүйлсийг олж харах нь

Тара Стрингам

2009 оны зуны нэгэн өдөр би найзынхаа нохойд нүүрээ уруулчихсан юм. Харамсалтай нь нохойд

уруулаа хазуулснаас оёдол тавиулах шаардлагатай болсонд би их сэтгэлээр унасан байсан.

Муу зүйлс толгойд минь эргэлдэж, амьдрал маань сүйрсэн мэт санагдаж байлаа. Гадаад төрхөөсөө санаа зовоод гадагшаа гарах ч дургүй болж, төгөлдөр хуур ба гар бөмбөг тоглож, усанд сэлж сүм болон сургуульд явах зэрэг бүгд боломжгүй болсон мэт санагдаж билээ.

Хэдийгээр ийнхүү сэтгэлээр унасан ч залбирах, зэрэгтнүүдээс адислал авах, эцэг эхтэйгээ ярилцах, гэр бүлийнхэн ба найз нөхөд минь над дээр зочилж ирсэн үед би урам зориг орж, аз жаргалтай болдог байлаа. Удалгүй би эдгээр хүмүүс намайг өрөвдөж байсныг ухаарсан.

Энэхүү ухаарал нь бусад хүмүүс намайг юу гэж бодох бол гэж дэндүү их санаа зовдог байдлаасаа ангижрахад тусалсан юм. Би хувиа хичээхээ больж бусдын төлөө санаа тавих хэрэгтэйг ойлгон, сүнс минь маш их хүчирхэгжсэн.

Бидэнд тохиолддог саад тотгорууд бол Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг гэдгийг би ойлгосон. Хэрвээ бид сайн зүйлсийг эрэлхийлвэл саад тотгороосоо суралцаж, илүү сайн хүмүүс болж, гэрчлэл маань хүчирхэгжих болно.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Эргэн тойрноосоо сайн сайхныг эрэлхийл

Хэрвээ та эргэн тойрноосоо сайн зүйлсийг эрэлхийлвэл олж чадна. Адислалуудаа таньж мэдэх нэг арга бол орой болгон тэр өдөр харсан сайн зүйлсээ тоолж сурах явдал юм.

Өнөө орой та цаг зав гаргаад гэр бүлийнхээ нэг гишүүнд өнөөдөр харсан сайн зүйлсийнхээ талаар хуваалцаарай.

© 2010 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хуулиар хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/10. Орчуулгын эхийн зөвшөөрөл: 6/10. *First Presidency Message, March 2011* -н орчуулга. Mongolian. 09763 363



Санваарын удирдлаган доор Санваартнуудын жаягаар

Энэ материалыг судалж, гэрээр нь очиж заадаг эгч нартай аль болох тохиромжтой арга замаар яриул. Эгч нарыг хүчирхэгжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд чинь идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Хайрт эгч нар аа бид ямар Их адислагдсан хүмүүс вэ! Бид зөвхөн сүмийн гишүүн төдийгүй — “Их Эзэний эмэгтэйчүүдийн байгууллага болох Нийгмийн халамжийн бүлгийн гишүүд билээ.”¹ Нийгмийн Халамжийн бүлэг нь Бурхан охиддоо хайртайгийн илрэл юм.

Та Нийгмийн Халамжийн бүлэг хэрхэн үүссэн талаар эргэн санахдаа сэтгэл тань догдолдоггүй гэж үү? 1842 оны 3-р сарын 17 нд Бошиглогч Иосеф Смит эгч нарыг “Санваарын удирдлаган дор Санваартнуудын жаягаар” зохион байгуулжээ.²

“*Санваарын удирдлаган дор*” эгч нарт эрх мэдэл болон заавар зөвлөгөөг өгөн зохион байгуулжээ. Нийгмийн Халамжийн бүлгийн 2 дахь ерөнхий ерөнхийлөгч Элиаза Р.Снөү заахдаа Нийгмийн Халамжийн бүлэг нь “Санваартнаас эрх мэдэл, нөлөөллийг авдаг учраас тэдэнгүйгээр оршин тогтнох аргагүй билээ” гэжээ.³ Арванхоёрын Чуулгын Төлөөлөгч Ахлагч Даллин Х.Өүк “Нийгмийн Халамжийн бүлгийн багш болон албан тушаалтнуудын эрх мэдэл нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмтэй холбоотой байгууллагуудаар болон зэрэгтнүүдийн гар

тавилтаар ирдэг тэрхүү эрх мэдэл юм” хэмээн тайлбарласан байдаг.⁴

“*Санваартнуудын жаягаар*” зохион байгуулагдсан учраас эгч нарт ариун үүрэг хариуцлага оногдсон. Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгч Жюли Б.Бэк “Бид санваарын арга барилаар ажилладаг тул илчлэлтийг эрэлхийлж, хүлээн авч, зөвлөлдөө шийдвэрүүдийг гаргадаг. Мөн бид бусдыг нэг бүрчлэн анхааран санаа тавьдаг. Бидний зорилго бол гэрээнүүдийг хийж, түүнийг сахин биелүүлснээр өөрсдийгөө мөнхийн амьдралын адислалуудад бэлдэх явдал мөн. Ийм учраас зэрэгтний нэгэн адилаар бидний зорилго бол авралын ажлуудыг хийх, үйлчлэл үзүүлэх мөн цэвэр ариун хүмүүс болох юм.”⁵

Барбара Томпсон Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх.

Судруудаас

1 Коринт 11:11; Сургаал ба гэрээ 25:3; 121:36–46

Бидний түүхээс

Навугийн Ариун сүмийг барих үеэр барилгын ажлыг дэмжих зорилгоор хэсэг эгч нэгэн бүлгийг үүсгэн байгуулжээ. Элиаза Р.Снөү

эгч энэхүү бүлгийн төслийг бичиж бошиглогч Иосеф танилцуулахад “Их Эзэн тэдний тусламжийг хүлээн авлаа. Их Эзэнд тэдэнд зориулсан илүү сайхан бэлэг бий хэмээн тэдэнд хэл. . . . Би эмэгтэйчүүдийг Санваарын удирдлаган доор Санваартнуудын жаягаар зохион байгуулна”⁶ гэж хэлжээ. Хэсэг хугацааны дараа шинэхэн үүсгэн байгуулагдсан Нийгмийн Халамжийн бүлгийнхэнд Бошиглогч “Энэ үе бол сайхь нийгэмлэгт ирээдүйд илүү агуу зүйлс тохиож, баяр баяслыг эдлэн тэнгэрээс мэдлэг, оюун билэг юүлэгдэн ирэх эхлэлийн үе мөн” гэж хэлжээ.⁷ Эгч нар ариун байдлын түвшинг өндөрсгөж, ариун сүмд хийх санваарын ёслолуудад бэлдэх ёстой байлаа.

ЭШЛЭЛ

1. Спенсер В.Кимбалл, “Relief Society— Its Promise and Potential,” *Ensign*, 1976 оны 3-р сар, 4.
2. Иосеф Смит, Сара Ж.Кимбал нарын “Намтар” болон *Эмэгтэйчүүдийн үлгэр дууриал* номоос эш татав.
3. Eliza R. Snow, “Female Relief Society,” *Deseret News*, 1868 оны 4-р сарын 22, 81.
4. Даллин Х.Өүк “Нийгмийн Халамжийн бүлэг ба Сүм,” *Ensign*, 1992 оны 5-р сар, 36.
5. Жюли Б.Бэкийн “Нийгмийн Халамжийн бүлэг: Ариун нандин Ажил” *Лиакхона*, 2009 оны 11-н сар, 111.
6. Иосеф Смит Кимбалын “Намтар” номын 51-ээс эш татав.
7. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалууд: Иосеф Смит* (2007), 64.

Би юу хийж чадах вэ?

1. Би хэрхэн айлчлан очдог эгч нартаа Нийгмийн Халамжийн бүлгийн ариун нандин ажлын адислалыг хүлээж авахад нь туслах вэ?

2. Энэ сард хувийн илчлэлт авах чадвараа хөгжүүлэхийн тулд би юу хийх ёстой вэ?

Нэмэлт мэдээллийг
www.reliefsociety.lds.org-aac
үзнэ үү.